



ТАХАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
Ц.АЗБАЯР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2016. 03. 25 № 3/551
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Тахарын ерөнхий газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Тахарын ерөнхий газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Тахарын ерөнхий газрын удирдлага 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2016\0325SAG22.Docx

УХА0122

070531



ТАХАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885
Цахим хаяг:
gunjidmaag@audit.gov.mn

Шинжээч: Б.Энхжин
Утас: 261740
Цахим хаяг: enkhjinb@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

2016 оны 3 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Тахарын ерөнхий газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд САГ-2016/17/СТА-ТТЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Тахарын ерөнхий газрын 2015 оны санхүүгийн нэгдсэн тайланд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Тахарын ерөнхий газрын 2015 оны санхүүгийн нэгдсэн тайланд санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 3 дугаар сарын 16-наас 2015 оны 3 дугаар сарын 24-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын санхүүгийн аудитын газрын шинжээч Б.Энхжин хэрэгжүүлэв.

Тахарын ерөнхий газрын 2015 оны санхүүгийн нэгдсэн тайланд 2016 оны 3 дугаар сарын 4-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2016 оны 3 дүгээр сарын 16-наас 2016 оны 3 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуульд заасан цаглабарын хугацаанд Тахарын ерөнхий газрын удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Хууль зүйн салбарын шинэчлэлийн бодлогын хүрээнд Тахарын албаны тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиуд батлагдсан.

Монгол улсад Тахарын албаны нэгдсэн тогтолцоог бий болгож, Тахарын албаны тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиг үүргийн хүрээнд тус албанд мөрдөгдөх дүрэм, журам, заавар боловсруулах календарчилсан төлөвлөгөөг батлуулж, Монгол Улсын Үндсэн хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Тахарын албаны тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам” болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээд дүрэм, журмын төслүүдийг боловсруулж, Хууль зүйн сайдын дангаар болон хамтарсан тушаалаар-9, Тахарын ерөнхий газрын даргын дангаараа болон хамтарсан тушаалаар-12 дүрэм, журмыг батлуулсан байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Тахарын албаны тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулиуд 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр батлагдаж, 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр дагаж мөрдөгдсөн. Засгийн газрын “Агентлаг байгуулах тухай” 07 дугаар тогтоол 2014 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр батлагдсанаар Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Тахарын ерөнхий газар байгуулагдсан. Тахарын ерөнхий газрын даргын 2014 оны 11 дугаар сарын 48 дугаар тушаалуудаар Гэрч хохирогчийг хамгаалах газар, Мөрдөн шалгах, эрэн сурвалжлах газар, 1-10 дугаар тойргийн Тахарын албаны орон тоо, албан тушаалын зэрэглэл батлагдсан байна.

Дөрөв.Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Тахарын ерөнхий газрын 2015 оны нэгтэгсэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Тахарын ерөнхий газар нь санхүүгийн үйл ажиллагаандаа тайлант онд

НББ-н бодлогын баримт бичгийг боловсруулан Тахарын ерөнхий газрын даргын 2015 оны А/57 дугаар тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн программд нийцсэн боловч тухайн салбарын онцлогт нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй нь учир дутагдалтай байна.

Тахарын ерөнхий газрын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Тахарын ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн Acolous 3.0 програмаар, салбарын нэгдгэсэн тайланг Plastic програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдлын суурийг нийт зардлын 2 хувиар буюу 181.7 сая төгрөгөөр тооцов.

Тав. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тахарын ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Зургаа.Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2015 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн орлого:

Тахарын ерөнхий газар нь 2015 онд Төсвийн урсгал санхүүжилт 12,327.0 сая төгрөгөөр батлагдсанаас 9,138.5 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Үндсэн үйл ажиллагааны орлого 0.8 сая төгрөг Тахарын албаны тухай хуулийн 15 дугаар зүйл “ яллагдагч, гэрчийг албадан ирүүлэх ажиллагаа”-ны зардал нөхөн төлүүлсэн орлого, ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын хувцасны тооцооны төлбөр, ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн цалингийн буцаалтын зөрүү, худалдан авах

ажиллагааны гэрээний үүргийн биелэлтийн алдангийн орлогоос бүрдсэн. (8-р тойргийн Тахарын алба 0.3 сая төгрөг, Тахарын ерөнхий газар 0.4 сая төгрөг)

Бусад орлого 50.6 сая төгрөг нь Ахмадын сангийн хөрөнгийг хуримтлуулсан орлого байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогын Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 13.9 сая төгрөг нь, Тахарын албаны тухай хуулийн 15 дугаар зүйл “ яллагдагч, гэрчийг албадан ирүүлэх ажиллагаа”-ны зардал нөхөн төлүүлсэн орлого, ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын хувцасны тооцооны төлбөр, Тахарын ерөнхий газар төрийн албан хаагчийн сул орон тоонд бүртгүүлэн шалгалт өгсөн хураамж, тендерийн баримт бичгийн үнэ зэрэг болно.

Нэмэлт санхүүжилтийн орлогын 0.6 сая төгрөг нь Олон улсын байгууллагас олгосон дэмжлэг, 41.5 сая төгрөг нь (Ховд 21.6 сая төгрөг, Өмнөговь 9.5 сая төгрөг, Дорноговь 0.5 сая төгрөг, Нийслэл 9.8 сая төгрөг) Нийслэл болон орон нутгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс үзүүлсэн дэмжлэгээс бүрдсэн байна.

Төсвийн зардлын гүйцэтгэл:

Тахарын ерөнхий газрын төсвийн захирагч нь 2015 онд урсгал төсөв 12,327.0 сая төгрөгөөр батлагдсанаас 8,924.3 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Тайлант оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлээр үндсэн цалингийн зардал 10.1 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын зардал 2.7 сая төгрөг, ҮОМШӨ-ий даатгалын зардал 3.3 сая төгрөг, байрны түрээсийн зардал 9.1 сая төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардал 3.1 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн боловч бүлэг тус бүрийн дүнгээр төсвийн зардлыг хэмнэлттэй зарцуулсан байна.

Долоо. Шилэн дансны мэдээлэл.

Takhar.gov.mn, Shilendans.gov.mn вэб сайтууд болон Мэдээллийн ил тод байдлын самбарт төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, худалдан авах ажиллагааны 2015 оны тайлан, 2016 оны төлөвлөгөө, 2016 оны батлагдсан төсөв, Тахарын ерөнхий газрын даргын тушаал, гэрээ зэрэг холбогдох шийдвэр, баримт бичгийг байршуулан ажиллаж байна.

Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдлүүдийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрт нарийвчилсан горим, сорил 12-г гүйцэтгэв.

Ес. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Тахарын ерөнхий газрын 2015 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, сургалт семинар зэрэг дансанд

ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Аудитын явцад Тахарын ерөнхий газрын 2015 оны санхүүгийн нэтгэсэн тайланд аудит хийх явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрлээ. Үүнд:

Тахарын ерөнхий газрын төсвийн 2015 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалын зардлаас 50.6 сая төгрөгөөр ахмадын санг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ын 1.3-д “Төсвийн байгууллага үйл ажиллагааны зардлын хэмнэлтээс, аж ахуйн нэгж, байгууллага үлдэгдэл ашгаас цалингийн нийт сангийн 3 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг жил бүр санд төвлөрүүлнэ”, Төсвийн тухай хуулийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.4-т “Төсвийн байгууллага нь батлагдсан тооноос дутуу орон тоогоор ажилласнаас бий болсон төсвийн үлдэгдэл” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитаар илэрсэн асуудалд албан шаардлага өгөхөөр болов.

Материаллаг бус дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тахарын ерөнхий газрын даргын 2014 оны А411 дүгээр тушаалыг үндэслэн Тахарын ерөнхий газрын ажилчдад тайлант онд нийт 83.3 сая төгрөгийн илүү цагийн хөлс олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 28.4, Тахарын ерөнхий газрын дотоод журмын 9.4 дэх заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төрийн албаны тухай хуулийн 28.4, Тахарын ерөнхий газрын дотоод журмын 9.4 дэх заалттай тус тус хэрэгжүүлж ажиллах зөвлөмж.

2. 2015 оны төсвийн төслийг боловсруулахдаа улирал бүр олгох үр дүнгийн урамшууллыг цалингийн сангийн нэмэгдэл цалингийн төсөвт төлөвлөж тайлант онд 27.7 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг нэмэгдэл цалингийн зардлыг төсвөөс олгосон байна.

Шийдвэрлэсэн: Сангийн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 5 дугаар тушаалын 6 дугаар хавсралтыг баримтлан урамшууллын зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах зөвлөмж өгөв.

Арван нэг. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Залруулагдах боломжгүй алдаа байхгүй.

Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тахарын ерөнхий газрын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Тахарын ерөнхий газрын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 232.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Үүнээс:

- ✓ 47.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж
- ✓ 155.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж
- ✓ 72.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага
- ✓ 7.7 сая төгрөгийн төлбөрийг барагдуулах акт тус тус өгөгдсөн байна.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

2014 оны аудитаар 9 зөвлөмж өгснийг биелүүлэн ажилласан байна.

Арван зургаа. Зөрчилгүй санал дүгнэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 11 тойргийн санхүүгийн тайлан нэгтгэгдэж 10 төсвийн шууд захирагч нь аудитад хамрагдаж зөрчилгүй санал дүгнэлт авсан ба 1 төсвийн шууд захирагч нь аудитын түүвэрт хамрагдсан байна. Тахарын ерөнхий газар нь 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн байна.



ТАХАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал.....11

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....12-19

2016 оны 3 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Тахарын ерөнхий газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Тахарын ерөнхий газрын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал	Тэргүүлэх ач холбогдол №1
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

- 1.1 Тахарын ерөнхий газрын даргын 2014 оны А411 дүгээр тушаалыг үндэслэн Тахарын ерөнхий газрын ажилчдад тайлант онд нийт 83.3 сая төгрөгийн илүү цагийн хөлс олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 74.2.4, Төрийн албаны тухай хуулийн 28.4, Тахарын ерөнхий газрын дотоод журмын 9.4 дэх заалттай тус тус нийцэхгүй байна.
- 1.2 2015 оны төсвийн төслийг боловсруулахдаа улирал бүр олгох үр дүнгийн урамшууллыг цалингийн сангийн нэмэгдэл цалингаар төлөвлөж тайлант онд 27.7 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг нэмэгдэл цалингаас олгосон байна.

ҮАГ-ын зөвлөмж

1. Хөдөлмөрийн тухай хуулийн 74.2.4, Төрийн албаны тухай хуулийн 28.4, Тахарын ерөнхий газрын дотоод журмын 9.4 дэх заалттай тус тус хэрэгжүүлж ажиллах.
2. Сангийн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 5 дугаар тушаалын 6 дугаар хавсралтыг баримтлан урамшууллын зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах.

Эрсдэлүүд

Батлагдсан төсвийг хэтрүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

			СТ-1А
ТАХАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН			
			/төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	940,658,205.73	1,456,018,061.51
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	50,356,833.22
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	50,356,833.22
31210	Төгрөг	-	50,356,833.22
31211	Төрийн сангийн харилцах		50,356,833.22
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	12,968,781.65	12,388,709.55
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		3,253,240.88
33300	Татаас, санхүүжилтийн авлага	6,991,027.00	2,894,406.13
33500	Бусад авлага	5,977,754.65	6,241,062.54
33510	Байгууллагаас авах авлага	4,624,000.00	6,241,062.54
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,353,754.65	
33620	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	-	-
34	УРЬДЧИЛГАА	-	6,640,000.00
34600	Урьдчилж гарсан зардал		6,640,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	927,689,424.08	1,386,632,518.74
35100	Түүхий эд материал	43,339,359.60	147,010,789.60
35110	Тусгай зориулалттай материал	30,565,879.60	128,689,182.60
35130	Эм боох материал	12,773,480.00	18,321,607.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	670,230,017.00	1,008,345,092.37
35400	Хангамжийн материал	214,120,047.48	231,276,636.77
35410	Бичиг хэргийн материал	32,512,078.70	22,097,767.00
35420	Аж ахуйн материал	13,731,409.82	29,314,209.10
35430	Сэлбэг хэрэгсэл	6,561,100.00	13,524,100.00
35440	Түлш, шатах тослох материал	84,286,423.96	63,359,787.84
35450	Барилгын засварын материал	2,455,150.00	2,205,950.00
35460	Хүнсний материал	153,490.00	722,129.00
35470	Бусад хангамжийн материал	74,420,395.00	100,052,693.83
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,609,284,920.07	1,984,049,419.51
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,609,284,920.07	1,984,049,419.51
39200	Биет хөрөнгө	1,598,345,649.08	1,960,756,648.14
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,295,270,252.00	2,434,958,860.89
39204	Хуримтлагдсан элэгдэл	(699,587,618.56)	(1,484,269,939.71)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	422,702,640.00	560,219,574.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(43,990,017.06)	(154,591,502.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	528,768,420.00	561,307,777.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,851,926.20)	(80,100,746.91)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	99,717,320.00	101,235,320.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	(1,826,494.57)	(1,164,369.87)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,036,395.00	26,342,275.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,357,321.53)	(6,003,592.17)
39217	Ном	1,464,000.00	2,822,992.00

39300	Биет бүс хөрөнгө	10,939,270.99	23,292,771.37
39301	Програм хангамж	12,100,000.00	29,452,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,160,729.01)	(6,159,228.63)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,549,943,125.80	3,440,067,481.02
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	831,140.00	11,181,352.63
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	831,140.00	11,181,352.63
41300	Өглөг	831,140.00	11,181,352.63
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		1,746,021.36
41360	Бусад өглөг	831,140.00	9,435,331.27
41361	Байгууллагад төлөх өглөг	831,140.00	9,435,331.27
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,549,111,985.80	3,428,886,128.39
51	Засгийн газрын хувь оролцоо	2,549,111,985.80	3,428,886,128.39
51200	Хуримтлагдсан үр дүн	2,549,111,985.80	2,999,485,377.95
51210	Өмнөх үеийн үр дүн	2,549,111,985.80	2,550,604,884.64
51220	Тайлант үеийн үр дүн		448,880,493.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		429,400,750.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,549,943,125.80	3,440,067,481.02

			СТ-2А
ТАХАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,362,535,031.58	9,102,054,465.05
12	ТАТВАРЫН БҮС ОРЛОГО	1,943,235,844.58	50,579,752.77
120	Нийтлэг татварын бүс орлого	1,943,235,844.58	50,579,752.77
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,943,235,844.58	50,579,752.77
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		814,076.08
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,943,235,844.58	49,765,676.69
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,419,299,187.00	9,051,474,712.28
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,204,333,860.00	8,923,890,150.62
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,204,333,860.00	8,923,890,150.62
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	214,965,327.00	124,746,022.66
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас		598,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид	202,856,000.00	41,525,155.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны	12,109,327.00	2,362,841.92
131106	Төсвийн урамшуулал		80,259,525.74
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	-	2,838,539.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		2,838,539.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,808,478,459.50	8,653,173,971.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,783,478,459.50	8,653,173,971.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,157,809,193.46	8,609,762,321.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,443,356,359.50	5,337,929,623.61
210101	Үндсэн цалин	2,109,118,699.96	4,544,290,630.73
210102	Нэмэгдэл	247,660,579.54	429,129,425.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	86,577,080.00	319,316,506.00
210104	Урамшуулал		45,193,061.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	182,803,775.16	181,136,084.21
210201	Тэтгэврийн даатгал	88,236,406.24	67,832,311.55
210202	Тэтгэмжийн даатгал	10,806,139.02	6,741,630.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,103,768.92	8,468,994.54
210204	Ажилгүйдлийн даатгал	2,304,909.63	1,581,730.93
210205	Эрүүл мэндийн даатгал	73,352,551.35	96,511,416.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,798,657.00	232,921,375.65

210301	Гэрэл, цахилгаан	10,312,638.00	26,758,596.50
210302	Түлш, халаалт	1,904,531.00	33,125,338.17
210303	Цэвэр, бохир ус	3,353,758.00	8,995,216.98
210304	Байрны түрээс	40,227,730.00	164,042,224.00
2104	Хангамж, бараа материалын зардал	303,893,263.90	621,416,010.15
210401	Бичиг хэрэг	67,364,925.30	89,041,878.35
210402	Тээвэр, шатахуун	163,087,654.93	399,437,041.12
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	44,858,403.49	83,297,271.96
210404	Ном, хэвлэл	7,780,387.00	8,587,810.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,654,393.18	40,399,028.72
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	147,500.00	
210408	Бараа материал акталсны зардал		652,980.00
2105	Нормативт зардал	354,759,327.60	146,636,981.76
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,936,960.00	5,420,172.00
210502	Хоол, хүнс	30,643,957.00	89,768,936.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	312,178,410.60	51,447,873.76
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	286,616,499.99	122,226,280.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,633,965.00	5,720,140.00
210602	Тавилга	1,995,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,447,502.00	84,400.00
210604	Урсгал засвар	267,540,032.99	116,421,740.00
2107	Томилолт, зочны зардал	194,323,251.30	119,808,421.80
210701	Гадаад албан томилолт	106,408,151.30	14,810,810.80
210702	Дотоод албан томилолт	87,269,920.00	104,997,611.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	645,180.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	73,548,697.34	43,639,328.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	72,161,044.34	3,146,890.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,496,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	276,070.00	22,282,581.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	514,683.00	4,302,980.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	596,900.00	3,475,147.30
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		8,935,530.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	262,709,361.67	1,804,048,216.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	620,000.00	1,434,767,280.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	111,828,657.00	71,496,405.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	150,260,704.67	297,784,531.26
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,625,669,266.04	43,411,650.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,943,404.00	43,453,550.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		2,838,539.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж		17,500,820.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,943,404.00	23,114,191.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,613,725,862.04	(41,900.00)
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,613,725,862.04	(41,900.00)
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,000,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	25,000,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	25,000,000.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,554,056,572.08	448,880,493.31
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,004,944,586.28	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,004,944,586.28	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,549,111,985.80	448,880,493.31

			СТ-2А
ТАХАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН			
			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	8,420,320,567.00	9,286,714,590.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	703,380.00	444,226.08
120	Нийтлэг татварын бус орлого	703,380.00	444,226.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	703,380.00	444,226.08
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	523,380.00	402,326.08
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	180,000.00	41,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,419,617,187.00	9,286,270,364.04
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,204,333,860.00	9,138,573,448.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,204,333,860.00	9,138,573,448.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	215,283,327.00	144,858,377.04
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		665,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	202,856,000.00	41,525,155.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,427,327.00	19,656,943.00
131106	Төсвийн урамшуулал		83,011,279.04
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	2,838,539.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		2,838,539.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,233,338,932.00	9,036,242,596.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,233,338,932.00	9,036,242,596.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,600,170,138.96	8,760,892,124.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,444,589,389.50	5,334,909,547.83
210101	Үндсэн цалин	2,110,351,729.96	4,519,867,600.95
210102	Нэмэгдэл	247,660,579.54	447,403,405.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	86,577,080.00	322,445,480.00
210104	Урамшуулал		45,193,061.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	182,854,827.34	183,786,387.00
210201	Тэтгэврийн даатгал	90,706,288.17	72,400,398.37
210202	Тэтгэмжийн даатгал	8,570,353.90	6,685,841.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,756,488.58	8,315,890.54
210204	Ажилгүйдлийн даатгал	1,802,096.47	1,554,356.93
210205	Эрүүл мэндийн даатгал	75,019,600.22	94,829,899.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,105,487.00	237,309,875.65
210301	Гэрэл, цахилгаан	13,189,393.00	26,769,096.50
210302	Түлш, халаалт	1,418,606.00	35,625,338.17
210303	Цэвэр, бохир ус	5,111,258.00	9,049,176.98
210304	Байрны түрээс	36,386,230.00	165,866,264.00
2104	Хангамж, бараа материалын зардал	488,674,597.49	595,931,194.76
210401	Бичиг хэрэг	101,305,723.00	77,136,012.00
210402	Тээвэр, шатахуун	245,491,737.00	362,314,451.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	51,170,963.49	83,581,126.96
210404	Ном, хэвлэл	9,259,487.00	10,289,063.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	81,446,687.00	62,610,541.00

2105	Нормативт зардал	730,038,490.00	471,064,094.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,489,900.00	8,860,509.00
210502	Хоол, хүнс	32,419,679.00	90,159,922.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	684,128,911.00	372,043,663.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	284,572,359.00	251,475,358.83
210601	Багаж, техник хэрэгсэл	23,118,381.00	121,553,403.83
210602	Тавилга	7,441,900.00	799,564.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,331,270.00	12,632,329.00
210604	Урсгал засвар	242,680,808.00	116,490,062.00
2107	Томилолт, зочны зардал	193,669,423.30	119,264,249.80
210701	Гадаад албан томилолт	84,240,000.00	14,810,810.80
210702	Дотоод албан томилолт	109,429,423.30	104,453,439.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	102,211,757.33	47,658,878.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,824,104.33	3,068,890.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,496,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	276,070.00	22,163,331.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	514,683.00	3,807,980.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	596,900.00	4,008,147.30
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		13,114,330.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	117,453,808.00	1,519,492,537.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	938,000.00	1,444,718,392.78
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	116,515,808.00	74,774,145.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,633,168,793.04	275,350,472.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,451,904.00	43,403,550.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		2,838,539.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		17,042,620.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,451,904.00	23,522,391.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,620,716,889.04	231,946,922.85
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,613,676,862.04	214,683,297.38
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,040,027.00	17,263,625.47
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,186,981,635.00	250,471,993.22
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,186,981,635.00	200,115,160.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,186,981,635.00	200,115,160.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,186,981,635.00	200,115,160.00
222001	Тоног төхөөрөмж	192,900,000.00	38,000,000.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	994,081,635.00	162,115,160.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,186,981,635.00)	(200,115,160.00)
VII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)=(III)+(VI)+(VII)	-	50,356,833.22
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		50,356,833.22

					СТ-4А
ТАХАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН					
					/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
7	Тайлант үеийн үр дүн			2,549,111,985.80	2,549,111,985.80
8	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,549,111,985.80	2,549,111,985.80
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын			1,492,898.84	1,492,898.84
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,550,604,884.64	2,550,604,884.64
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		429,400,750.44		429,400,750.44
15	Тайлант үеийн үр дүн			448,880,493.31	448,880,493.31
16	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	429,400,750.44	2,999,485,377.95	3,428,886,128.39

20